

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

342.	Конвенцийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай	Дугаар 281	1437
343.	Зарим компанийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай	Дугаар 290	1447

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 8 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 281

Улаанбаатар
хот

Конвенцийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, түүний нэмэлт протоколын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг 2013-2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, иргэний нийгмийн оролцоотойгоор салбар, орон нутгийнхаа түвшинд хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв болон Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад тусгах, мөн гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэх замаар хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, Сангийн сайд Ч.Улаан, холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 1 дүгээр сард багтаан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд ирүүлж байхыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын нэгдсэн тайланг жил бүрийн II улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД**

С.ЭРДЭНЭ

Засгийн газрын 2013 оны 281 дүгээр
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ” НҮБ-ЫН КОНВЕНЦИЙГ
2013-2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Гарах үр дүн	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Санхүүжилтийн эх үүсвэр		
							Дотоод	Гадаад	
	Нэг. Хууль эрх зүйн орчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх статистик тоо мэдээг сайжруулах хүрээнд								
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх бодлого, эрх зүйн актын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт гаргах	2013	ХАХНХЯ	Дэлхийн банк	Бодлого, хууль эрхийн актын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид хийх ажлын дүр зураг гарч ирнэ	Судалгааны ажлын тайлан, үнэлгээ дүгнэлт	Улсын төсөв	ОУБ-уудын дэмжлэг	
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай (бие даасан) хуулийг боловсруулах	2013-2014	ХАХНХЯ	Холбогдох ажлын хэсэг	Конвенцийн үзэл санаанд нийцсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие даасан хуультай болох	Хуулийн төсөл боловсруулж УИХ-д өргөн баригдсан байх	Улсын төсөв	-	
3	Хууль тогтоомжид нийцүүлэн шаардлагатай журам, дүрэм, стандарт боловсруулах	2013-2016	ХАХНХЯ	ХЗЯ, ЭМЯ, БШУЯ, ЗТЯ, БХБЯ, ХЯ, СЯ	Конвенцийн зарчим, үзэл санаа үндэсний хууль тогтоомж, эрх зүйн актад тусгалаа олж, хууль эрх зүйн орчин сайжирна	Боловсруулсан баримт бичгийн төсөл	Улсын төсөв	Дэмжигч байгууллага	



4	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хэрэгжилтэд үнэлгээ хийж холбогдох арга хэмжээг авах	2013-2016	ХАХНХЯ	Яамд, МХЕГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ-үүд	Хуулийн хэрэгжилт сайжирна	Хуулийн хэрэгжилтийг хангуулах, сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагад хүргүүлсэн санал, зөвлөмж, шаардлагын тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
5	Өөрийн орны онцлог, нөхцөл байдалд нийцүүлэн ICF ангиллыг нэвтрүүлэх	2014-2016	ХАХНХЯ ЭМЯ	БШУЯ, ҮСХ, ТББ, ОУБ	Хөгжлийн бэрхшээлийн чадвар алдалтыг тодорхойлох боломж нэмэгдэнэ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтоох аргачлал бий болно	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн талаарх мэдээллийн нэгдсэн сан бий болгох	2014-2015	ХАХНХЯ	ХАХНХЯ, БШУЯ, ҮСХ, ТББ, ОУБ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг төлөвлөхөд мэдээллийн сан гол бааз суурь болно	Мэдээллийн сан бий болно	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
Хоёр. Эрүүл мэнд болон сэргээн засах тусламж, үйлчилгээг сайжруулах хүрээнд								
7	Хөгжлийн бэрхшээлийг эрт оношлох, илрүүлэх аргачлалыг боловсруулах	2013-2016	ХАХНХЯ	ЭМЯ, БШУЯ, ТББ, ОУБ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэлт сайжирч, эмчлэгдэх, давхар	Мэдээллийн сан	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг

					Хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх боломж нэмэгдэнэ	Тус төвөөр оношлуулж, эмчилгээнд хамрагдсан хүний тоо хангагдсан байна	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
8	СЗХУТ-ийн эрт эмчилгээ, оношлогооны төвд шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслээр хангах	2015-2016	ХАХНХЯ	ЭМЯ, ОУБ	Эрт оношлогоо эмчилгээний төвд шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслээр хангагдсан байна	Хүүхэд хөгжлийн төв байгуулагдсан байна.	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг аймаг, дүүрэг бүрт байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулах	2013-2016	ХАХНХЯ	Аймаг, дүүргийн Засаг дарга	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэдний эцэг, эхчүүд нийгмийн үйлчилгээг цогцоор авах боломжтой болно		Улсын болон орон нутгийн төсөв	
10	Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг холбогдох яамд, төрийн байгууллагад тогтмол зохион байгуулах	2013-2016	ЭМЯ	Хэвлэл, мэдээллийн байгууллага, ТББ, ОУБ	Олон нийтийн ойлголт, мэдлэг, хандлага тодорхой хэмжээнд сайжирна	Зохион байгуулсан арга хэмжээ, мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагууд зохион байгуулах	2013-2016	ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	ТББ, ОУБ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлийн талаар ойлголт, мэдлэгтэй болно	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг



12	Олон нийтийн оролцоонд тушиглан сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, олон улсын жишиг загвар үйлчилгээний шалгуур, стандартыг боловсруулж нэвтрүүлнэ	2014-2016	ХАХНХЯ	ЭМЯ, ТББ, ОУБ	Сэргээн засах тусламж, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн, эрэлт хэрэгцээг нь хангахуйц байна	Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээ болон үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
13	Протез, ортопед, тусгай хэрэгслийн дотоодын үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	2014-2016	ҮХААЯ	ХЯ, ХАХНХЯ, ТББ, ОУБ	Дотоодын үйлдвэрлэлийг дэмжсэнээр гадны зах зээлд өрсөлдөхүйц түвшинд хүрэхэд зохих хувь нэмэр оруулна	Нэвтрүүлсэн техник, үйл ажиллагаа нь дэмжсэн дотоодын үйлдвэрлэлийн тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
14	Сэргээн засах тусламж, үйлчилгээний өртөг, зардлын судалгаа хийж, санхүүжилтийг тодорхой болгох	2014-2015	ЭМЯ	ХАХНХЯ, СЗХУТ, НДЕГ	Сэргээн засах тусламж үйлчилгээний чанар сайжирна	Тусламж үйлчилгээний өртөг зардлын судалгаа хийгдэж санхүүжилт боловсронгуй болно.	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
15	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх сэргээн засах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр гадаад орноос авах тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх	2013 -2016	ЭМЯ,	ХАХНХЯ, СЯ, ГХЯ, ЭЗХЯ, ТББ	Сэргээн засах тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдэнэ	Гадаадын хөрөнгө оруулалттай 4-5 төсөл хэрэгжсэн байна	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг

	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэл урьдчилан сурталчилгаагаар хангах өдөртэй болох (Жил бүрийн 5 сарын 13)	2013-2016	ЭМЯ	ХАХНХЯ	Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэгдэж мэдээ мэдээллээр хангагдана	Өдөр зохион байгуулагдсан байна	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
16	Гурав. Боловсролын үйлчилгээ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах боловсон хүчнийг нэмэгдүүлэх, чадвархижуулах хүрээнд							
17	Дохионы хэлний стандартыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх	2013	БШУЯ	Судалгаа, шинжилгээний байгууллага, ТББ, ОУБ	Сонстолын бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээ, олон улсын жишигт нийцсэн стандарттай болно	Стандартын төсөл	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
18	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын бэрхшээлийн онцлогт тохирсон тусгай хэрэгцээг сургалтын баазыг бэхжүүлэх, сургалт, арга зүйн төв болгон өргөжүүлэх	2013-2016	БШУЯ	ТББ, ОУБ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсроход шаардлагатай гарын авлага, материал, тоног төхөөрөмжийн хүрэлцээ сайжирна	Сурах бичиг, гарын авлага, тоног төхөөрөмжийн тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
19	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг бүх төрлийн мэргэжлийн боловсон хүчнийг дотоод, гадаадад сургах, туршлага судлуулах, давтан сургах хөтөлбөр боловсруулан	2014-2016	БШУЯ	ЭМЯ, ХАХНХЯ, ТББ, ОУБ	Олон улсын жишиг, чиг хандлагад нийцсэн боловсролтой ажилтнуудын тоо нэмэгдэж улмаар нийгмийн	Гадаадад суралцсан, туршлага судалсан хүмүүсийн тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг



	хэрэгжүүлэх				үйлчилгээг олон улсын жишигт хүргэхэд зохих хувь нэмэр оруулна				
20	Ерөнхий боловсролын сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор жишиг загвар сургууль бий болгох	2015-2016	БШУЯ	ХАХНХЯ, ТББ, ОУБ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин нөхцөл сайжирна	Жишиг загвар сургууль бий болсон байна	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг	
21	Төр, хувийн хэвшлийн байгууллагын удирдах ажилтнууд, багш, эмч, нийгмийн ажилтан болон холбогдох ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх хандлагын талаар сургалт зохион байгуулах	2013-2016	ХАХНХЯ	ТББ, ОУБ	Хөгжлийн бэрхшээлийн талаар баримталж байгаа дэлхий нийтийн чиг хандлагыг нэвтрүүлэх	Сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг	
22	Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр гадаад орнуудад зохион байгуулагддаг сургалт, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг оролцоход дэмжлэг үзүүлэх	2014-2016	БШУЯ	ХАХНХЯ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдлэг чадварыг сайжирна	Сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг	
23	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг	2013-2016	БШУЯ	ХАХНХЯ, ЭМЯ, ТББ	Судалгааны ажлын дүгнэлт, зөвлөмж дээр үндэслэн үйл	Хийгдсэн судалгааны тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг	

явуулах	ажиллагаа төлөвлөгдөж хэрэгжинэ	төсөв	ОУБ-уудын дэмжлэг
24	Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөгөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтэд түшиглэн хөгжүүлэх ойлголт хандлагыг оруулж хэрэгжүүлэх	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
Дөрөв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, тэдэнд ээлтэй орчин, нөхцөлийг сайжруулах хүрээнд			
25	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих тусгай зориулалтын болон тусгай тоноглолтой нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих боломж нэмэгдэнэ	Тусгай тоноглол болон тусгай хэрэгсэлтэй нийтийн тээврийн хэрэгслийн тОО
26	Аливаа бүтээн байгуулалт барилгын ажлын зураг төслийг батлах, барилга байгууламжийг хүлээн авах комисст хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оруулах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар батлагдсан орчны дэд бүтцийн стандартын хэрэгжилт сайжирна	Улсын болон орон нутгийн төсөв
27	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцанд хамруулах асуудлыг судлан хэрэгжүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааны түвшин дээшлэнэ	Улсын болон орон нутгийн төсөв



Сонстолын бэрхшээлтэй иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хүргэмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор дохионы орчуулга, урсдаг титрийг тогтмолжуулах	2013-2016	МТШХХГ	ОНРТХЭГ, Арилжааны телевизүүд, ТББ, ОУБ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хэрэгслийн хүргэмж нэмэгдэнэ	Тотмол цаг олгосон хэвлэл, мэдээллийн байгууллагын тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр" хэрэгжүүлэх	2014-2016	ХЯ	УХААЯ, ССАЖЯ, ГХЯ, МХАУТ, ТББ	Үндэсний хэмжээний хөтөлбөр хэрэгжсэн байна	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг	
Тав. Соёл, спорт, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх хүрээнд							
Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэдийн спорт, урлагийн их наадамьг 4 жилд нэг удаа зохион байгуулах	2013-2016	ССАЖЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо сайжирч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт, хандлага нэмэгдэнэ	4 жилд нэг удаа зохион байгуулагдсан байна	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд оролцох нөхцөлийг хүргэмжтэй болгох зорилгоор тусгай хэрэгцээг хангасан байх	2013	СЕХ		Үйл ажиллагааны бэрхшээлтэй иргэд сонгуульд оролцох эрхээ эдлэх боломж нэмэгдэнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Улсын болон орон нутгийн төсөв	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг жил бүр улсын хэмжээнд тэмдэглэж, хэвшүүлэх	2013-2016	ХАХНХЯ	Аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ-ууд	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр хийж байгаа ажлаа тайлагнаж завшилцнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг
Соёл, урлаг, спортын чиглэлээр зохиогдож буй арга хэмжээнд ХБЯ-ийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах	2013-2016	ССАЖЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвхи оролцоо сайжирна	Хамтран оролцсон урлаг, спортын арга хэмжээний тоо	Улсын болон орон нутгийн төсөв	ОУБ-уудын дэмжлэг



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 8 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 290

Улаанбаатар
хот

Зарим компанийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.1, 16.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, аж ахуйн нэгжийн хүсэлт болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны саналыг үндэслэн дор дурдсан компанийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай:

№	Компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил
1	“Дорнын говь” ХХК (1996 онд “Чандмань” ББХК нэрээр зөвшөөрөл авсан)	Спирт, архи	Дорноговь аймаг
2	“Мөнхөд мандаг” ХХК	Архи	Завхан аймаг
3	“Биндэръяа” ХХК	Архи	Завхан аймаг
4	“НСМ” ХХК	Архи	Завхан аймаг



2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙД**

Х.БАТТУЛГА

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 14003